



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2025 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

“Чингэлтэйн ахмадууд-2028”  
арга хэмжээ батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.8, 35.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит III хуралдаанаас ТОГТООХ нь:

1. “Ахмад настны хөгжлийн төв”-ийг бүсчилсэн хэлбэрээр байгуулж, ахмад настны эрхийг хангах, эрүүл мэндийг хамгаалах, идэвхтэй хөдөлгөөнийг сурталчлан эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлэх, нийгмийн оролцоо идэвхийг нэмэгдүүлж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, амьдралын чанарыг дээшлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилго бүхий “Чингэлтэйн ахмадууд-2028” арга хэмжээг хавсралт ёсоор баталсугай.

2. Арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжилтийг жил бүр дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг дүүргийн Засаг дарга (Н.Мандуул)-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авч ажиллахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Зөвлөлд үүрэг болгосугай.

ДАРГА



Т.УЛАМБАЯР

Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын 2025 оны 03 дугаар сарын 28-ны  
өдрийн 06 дугаар тогтоолын хавсралт

## “ЧИНГЭЛТЭЙН АХМАДУУД-2028” АРГА ХЭМЖЭЭ

### Нэг.Нийтлэг үндэслэл

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн хэмжээнд ахмад настанд чиглэсэн нэгдсэн бодлогыг тодорхойлж, дунд хугацааны буюу дөрвөн жилийн хугацаанд хэрэгжүүлэх бодлогын баримт бичгийг боловсруулан хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлагын дагуу Ахмад настны тухай хууль, “Алсын хараа-2025” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэл, дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан “Чингэлтэйн ахмадууд-2028” арга хэмжээг боловсрууллаа.

Мөн Дэлхийн Эрүүл мэндийн байгууллагаас ахмад настны цогц тусламж үйлчилгээг өөрийн орны нөхцөл байдалтай уялдуулан үзүүлэх эрх зүйн зохицуулалт хийх зөвлөмжийн дагуу Монгол улсын хувьд Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, эрх зүйн шинэчлэлийг хийсэн төдийгүй Монгол Улсын Засгийн газраас ахмад настны эрхийг баталгаажуулж, хөгжлийг дэмжсэн эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх, амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн цогц бодлогын олон арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тухайлбал, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн зөрүүг ойртуулах, тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой шийдвэр гарган, Нийгмийн даатгалын багц хуулийг Улсын Их Хурлаар батлуулж, тэтгэврийн хэмжээг жил бүр инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх итгэлцүүрийг улсын дундаж цалин, хэрэглээний үнийн өөрчлөлттэй уялдуулан жил бүр шинэчлэн тогтоож мөрддөг байхаар тусгасан. Ингэснээр ахмад настнуудад нийгмийн даатгал болон нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр тогтоолгох боломжийг бүрдүүлж, тэтгэвэр тогтоолгох боломжгүй байсан ахмад настнуудын асуудлыг шийдвэрлэсэн нь ахмад настны нийгмийн баталгааны чухал үзүүлэлт болсон юм.

Чингэлтэй дүүргийн хувьд “Ахмад настны хөгжлийн төв”-ийг бүсчилсэн хэлбэрээр байгуулж, ахмад настны эрхийг хангах, эрүүл мэндийг хамгаалах, идэвхтэй хөдөлгөөнийг сурталчлах, эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлэх, нийгмийн оролцоо идэвхийг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, амьдралын чанарыг дээшлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх чиглэлээр “Чингэлтэйн ахмадууд-2028” арга хэмжээг хэрэгжүүлэхээр дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан.

Дэлхийн хүн амын 10 хувийг 65 ба түүнээс дээш насны ахмадууд 2022 онд эзэлж байсан бол 2030 онд 12 хувь, 2050 онд 16 хувийг эзэлж 1,6 тэрбумд хүрэх тооцоолол байгаа бөгөөд Монгол Улсын хувьд 2010 онд 60-аас дээш насны ахмадын тоо нийт хүн амын 5,8 хувийг эзэлж байсан бол 2021 онд 9,7 хувь, 2030 онд 11,9 хувь, 2050 онд 5 хүн тутмын нэг нь 60 ба түүнээс дээш насыг наслах тооцооллыг Үндэсний статистикийн хорооноос гаргасан. Монгол улсын хүн амын дундаж наслалт 71,5, эрэгтэй хүний дундаж наслалт 67,6, эмэгтэй хүний дундаж наслалт 76,8 буюу дундаж наслалтын зөрүү 9,2 жилээр зөрүүтэй байна.

Монгол улсын хэмжээнд 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 385,000 ахмад настан бүртгэлтэйгээс Чингэлтэй дүүрэгт 18300 гаруй ахмад настан бүртгэлтэй байгаа бөгөөд дүүргийн хэмжээнд ахмад настны тоо жил ирэх тутамд нэмэгдэж байгаа тул ахмад настанд чиглэсэн цогц бодлогыг тодорхойлж, бодлогын баримт бичгийг боловсруулан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж, орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлагатай байгаа юм.

### **Хоёр.Арга хэмжээний зорилго**

“Ахмад настны хөгжлийн төв”-ийг бүсчилсэн хэлбэрээр байгуулж, ахмад настны эрхийг хангах, эрүүл мэндийг хамгаалах, идэвхтэй хөдөлгөөнийг сурталчлан эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлэх, нийгмийн оролцоо идэвхийг нэмэгдүүлж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, амьдралын чанарыг дээшлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэхэд арга хэмжээний зорилго оршино.

### **Гурав.Арга хэмжээний зорилтууд, хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, хүрэх үр дүн**

**Зорилт 1.Ахмадын хөгжлийн төвийг бүсчилсэн хэлбэрээр байгуулж, ахмад настуудын хөгжих, нийгмийн дунд эрүүл идэвхтэй амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлнэ.**

Зорилт 1-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

1.1.Нийгмийн оролцоог хангах, хөгжих, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зориулалт бүхий “Ахмадын хөгжлийн төв”-ийг бүсчилсэн хэлбэрээр байгуулж, үйл ажиллагааг нь тогтмолжуулна.

1.2.“Ахмадын хөгжлийн төв”-д ахмад настуудад зориулсан нийгэм, сэтгэл зүйн болон зөвлөгөө мэдээлэл өгөх чиг үүрэг бүхий ажилтан, албан хаагчдыг ажиллуулахаар бүтэц, орон тоог батлуулна.

1.3.“Ахмадын хөгжлийн төв” нь ахмад настны эрэлт, хэрэгцээнд нийцсэн хөгжлийн болон нийгмийн үйлчилгээг тогтмол үзүүлж, идэвхтэй насжилтыг дэмжинэ.

1.4.Ахмад настуудыг нийтийн биеийн тамир, спорт, соёл урлагийн үйл ажиллагаанд идэвхтэй хамруулж, энэ чиглэлийн барилга байгууламж, заал талбайг үнэ төлбөргүй ашиглуулах, ахмад настуудын дунд биеийн тамир, спорт, урлаг соёлын арга хэмжээг тогтмол зохион байгуулж, ахмад настуудын үүсгэл

санаачилгаар байгуулсан баг, хамтлаг, клубийн үйл ажиллагааг дэмжиж, эрүүл амьдралын эрүүл хэв маягийг хэвшүүлнэ.

**Хүрэх үр дүн:**

- “Ахмадын хөгжлийн төв”-ийг бүсчилсэн хэлбэрээр байгуулж, үйл ажиллагаа тогтмолжино.
- Ахмад настуудын нийгмийн идэвх оролцоо сайжирч, эрүүл амьдралын хэв маягт суралцсан байна.

**Зорилт 2.Ахмад настанд зориулж насжилтаас үүдэлтэй өвчлөлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулна.**

Зорилт 2-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

2.1.Дүүргийн Эрүүл мэндийн төв, 1-24 дүгээр хороодын Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй хамтран ахмад настуудад зориулж насжилтаас үүдэлтэй өвчлөлөөс урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоо, зөвлөгөө мэдээлэл, сургалт сурталчилгааны ажлыг хагас жил тутамд тогтмол зохион байгуулна.

2.2.Дүүргийн Эрүүл мэндийн төвд ахмад настуудад зориулсан сэргээн засах, уламжлалт эмчилгээний тасаг байгуулж, шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангах, ахмад настуудыг Эрүүл мэндийн төвд харьяалуулж, тогтмол хяналтад байх механизмыг бий болгоно.

2.3.Дүүргийн 1-24 дүгээр хороодын Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд ахмад настуудад эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлэх Ахмадын эмчийг тогтмол ажиллуулж, үйл ажиллагааг нь дэмжиж ажиллана.

2.4.Дүүргийн “Хоймор хайрхан амралт”-ыг түшиглэн ахмадын сувиллыг байгуулж, ахмад настуудыг асран сувилах, өдрөөр эмчлэх, асаргааны хувилбарт үйлчилгээг сайжруулах чиглэлд анхаарч, мэргэжлийн баг, тусгайлан бэлтгэсэн сайн дурын ажилтнуудыг оролцуулна.

**Хүрэх үр дүн:**

- Ахмад настууд насжилтаас үүдэлтэй өвчлөлөөс урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоо, зөвлөгөө мэдээлэл, сургалт сурталчилгааны ажилд тогтмол хамрагдаж, энэ чиглэлийн ойлголт мэдлэгтэй болсон байна.
- Өдрөөр эмчлэх, асрах сувилах, асаргааны хувилбарт үйлчилгээний чанар хүртээмж сайжирч, сайн дурын байгууллагуудтай хамтран ажиллах боломж нөхцөл бүрдэнэ.

**Зорилт 3.Ахмад настуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, шинэ ур чадварт суралцуулж, амьдралын чанарыг дээшлүүлсэн байна.**

Зорилт 3-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

3.1.Хөдөлмөр эрхлэх хүсэл сонирхолтой ахмад настнуудыг мэдээллийн санд бүртгэж, мэдлэг чадварт нь тохирсон ажлын байранд зуучлах, жижиг зээл олгох, нөхөрлөл хоршооны хэлбэрээр үйл ажиллагаа явуулах, хөдөлмөр эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэхэд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.

3.2.Ахмад настнуудын залуу хойч үедээ өвлүүлэн үлдээх боломжит сургалтуудыг тогтмол зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, ахмад, дунд, залуу үеийн холбоо хэлхээг сайжруулж, амьдрах ухаан, аж ахуй эрхлэх болон бусад чиглэлээр танхимын, зайн, шавь сургалт явуулах орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

3.3.Ахмад настнуудын үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг сурталчлан таниулах, туршлага солилцох, сайн туршлагыг нутагшуулах, өвлүүлэн үлдээх чиглэлээр үзэсгэлэн худалдааг зохион байгуулж хэвшинэ.

#### **Хүрэх дүн:**

- Ахмад настнуудыг ажлын байранд зуучлан, өрхийн орлого нэмэгдүүлж, амьжиргааны түвшинг дээшлүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлсэн байна.
- Бизнес инкубацийн үйлчилгээ, зээл тусламжид хамруулж, сайн дурын нөхөрлөл хоршоо байгуулах зэргээр хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлсэн байна.

**Зорилт 4.Ахмад настны нийгмийн хамгааллыг сайжруулж, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр нөлөөллийн үйл ажиллагааг тогтмол зохион байгуулна.**

Зорилт 4-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

4.1.Төрсөн үр хүүхэдгүй, ганц бие, бие даан амьдрах чадваргүй ахмад настанд нийгмийн хамгааллын үйлчилгээг үзүүлж, шаардлагатай тохиолдолд ахмад настны асрамж халамжийн газарт холбон зуучлах ажлыг хэрэгжүүлнэ.

4.2.Ахмад настныг ялгаварлан гадуурхал, гэр бүлийн хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

#### **Хүрэх үр дүн:**

- Ахмад настнуудад нийгмийн хамгааллын үйлчилгээг хүргэх боломж нөхцөл бүрдсэн байна.
- Гэр бүлийн хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлж, ахмад настнуудын хүчирхийлэлд өртөх эрсдэлийг бууруулна.

#### **Дөрөв.Арга хэмжээг хэрэгжүүлэх зарчмууд**

*Тэгш хүртээмжтэй байх:*

- ✓ Ахмад настнуудыг нийгмийн хөгжил, хамгааллын олон талт үйл ажиллагаанд тэгш хүртээмжтэй хамруулж, идэвх оролцоог нэмэгдүүлж, дэмжин ажиллана.

*Үндэсний өв, соёлд тулгуурлах:*

- ✓ Үндэсний өв уламжлалыг үр хойч үедээ өвлүүлэн уламжлуулах, сурталчлан таниулах, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, нутагшуулах ажлыг дэмжин ажиллана.

*Шинээр санаачлагч, бүтээгч байх:*

- ✓ Ахмад настны нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, амьдралын чанарыг дээшлүүлэх чиглэлээр шинээр санаачлан хэрэгжүүлэх сургалт, нөлөөллийн ажлыг дэмжин ажиллана.

*Харилцан уялдаа, холбоотой байх:*

- ✓ Арга хэмжээг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, нөхөрлөл хоршоо, аж ахуйн нэгж, иргэдийн хамтын ажиллагааг бэхжүүлж, ахмад настныг дэмжих чиглэлээр зохион байгуулж буй үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн байгууллага, олон нийтийн сүлжээгээр сурталчлан таниулж ажиллана.

#### **Тав.Арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилт**

5.1.“Чингэлтэйн ахмадууд-2028” арга хэмжээг 2025-2028 он хүртэл нийт 4 жилийн хугацаанд 4 зорилт, 13 үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд хэрэгжүүлнэ.

5.2.Арга хэмжээний санхүүжилт дараах эх үүсвэрээс бүрдэнэ.

5.2.1.Улс, нийслэлийн төсөв

5.2.2.Орон нутгийн төсөв

5.2.3.Олон улсын болон төрийн бус байгууллагын дэмжлэг

5.2.4.Бусад эх үүсвэр

#### **Зургаа.Арга хэмжээний удирдлага, зохион байгуулалт**

6.1.Арга хэмжээний хэрэгжилтийг дүүргийн Засаг даргын Тамгын газар орон нутгийн хэмжээнд удирдлага, төлөвлөлт, арга зүй, зохион байгуулалтаар хангаж ажиллана.

6.2.Арга хэмжээг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус, олон улсын байгууллага, нөхөрлөл хоршоо, аж ахуйн нэгж, иргэд, олон нийт, ахмад настнуудын дэмжлэг туслалцаа, идэвх оролцоог хангаж ажиллана.

6.3.Арга хэмжээний хэрэгжилтийг хэвлэл мэдээллийн байгууллага, олон нийтийн цахим сүлжээгээр тогтмол сурталчлан ажиллах ба ахмад настнуудын сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, нутагшуулах чиглэлд анхаарч ажиллана.

## Долоо.Арга хэмжээний хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээ, үр дүн, шалгуур үзүүлэлт

### Хяналт-шинжилгээ, үнэлгээ:

- Дүүргийн Засаг даргын Тамгын газар нь оролцогч талуудыг тэгш оролцоог хангаж, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ба үр дүнгийн хэрэгжилтийг жил бүр гаргаж, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнана.
- Арга хэмжээний хэрэгжилтийг зорилтын биелэлт, үйл ажиллагааны чиглэлийн үр дүнгээр үнэлнэ.

### Арга хэмжээний үр дүн:

- Арга хэмжээний хүрээнд дүүргийн хэмжээнд Ахмадын хөгжлийн төв бүсчилсэн хэлбэрээр 5-6 байршилд байгуулагдсан байна.
- Ахмад настнуудад үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж дээшилсэн байна.
- Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, амьдрах орчин, амьдралын чанарт ахиц өөрчлөлт гарсан байна.
- Өрхийн үйлдвэрлэл, хувиараа хөдөлмөр эрхэлдэг ахмад настнуудыг зээл тусламжид хамруулан, үйл ажиллагаагаа өргөтгөхөд нь дэмжлэг үзүүлж, шинэ ажлын байрыг бий болгосон байна.

### Шалгуур үзүүлэлт:

| №                                                                                                                                                                 | Шалгуур үзүүлэлт                                                                      | Хэмжих нэгж | Суурь түвшин<br>2024 он | Зорилтот түвшин |            |            |            |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------|-------------|-------------------------|-----------------|------------|------------|------------|
|                                                                                                                                                                   |                                                                                       |             |                         | 2025<br>он      | 2026<br>он | 2027<br>он | 2028<br>он |
| 1                                                                                                                                                                 | 2                                                                                     | 3           | 4                       | 5               | 6          | 7          | 8          |
| <b>Зорилт 1. Ахмадын хөгжлийн төвийг бүсчилсэн хэлбэрээр байгуулж, ахмад настнуудын хөгжих, нийгмийн дунд эрүүл, идэвхтэй амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлнэ.</b> |                                                                                       |             |                         |                 |            |            |            |
| 1.                                                                                                                                                                | Ахмад настны хөгжлийн төв байгуулсан эсэх                                             | Тоо         | 1                       | 2               | 3          | -          | -          |
| 2.                                                                                                                                                                | Ахмад настны хөгжлийн төвийн ажилтан, албан хаагчдын бүтэц, орон тоог баталсан байдал | Тоо         | 1                       | 2               | 3          | -          | -          |
| 3.                                                                                                                                                                | Ахмад настны хөгжлийн төвөөр дамжуулан ахмад настнуудад үзүүлсэн үйлчилгээ            | Тоо         | 4                       | 12              | 24         | 24         | 24         |

|   |                                                                                                        |     |     |      |      |      |      |
|---|--------------------------------------------------------------------------------------------------------|-----|-----|------|------|------|------|
| 4 | Ахмад настны хөгжлийн төвөөр дамжуулан ахмад настнуудад үзүүлсэн үйлчилгээнд хамрагдсан ахмад настнууд | Тоо | 400 | 1200 | 2400 | 2400 | 2400 |
|---|--------------------------------------------------------------------------------------------------------|-----|-----|------|------|------|------|

Зорилт 2. Ахмад настанд зориулж насжилтаас үүдэлтэй өвчлөлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулна.

|    |                                                                                                                                                                          |      |    |    |    |    |     |
|----|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------|----|----|----|----|-----|
| 1. | Ахмад настнуудыг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоо, зөвлөгөө мэдээлэл, сургалт сурталчилгаанд хамруулсан байдал                                              | Тоо  | 2  | 4  | 4  | 4  | 4   |
| 2. | Сэргээн засах, уламжлалт эмчилгээний тасгийг нээн ажиллуулсан эсэх                                                                                                       | Тоо  | -  | 1  | -  | -  | -   |
| 3. | Өрхийн Эрүүл мэндийн төвүүдэд Ахмадын эмчийг тогтмол ажиллуулж байгаа эсэх                                                                                               | Тоо  | 16 | 16 | 16 | 16 | 16  |
| 4. | Ахмад настныг өдрөөр эмчлэх, асран сувилах, асаргааны хувилбарт үйлчилгээг сайжруулахад мэргэжлийн баг, тусгайлан бэлтгэсэн сайн дурын ажилтнуудыг оролцуулж байгаа эсэх | Хувь | -  | 30 | 50 | 70 | 100 |

Зорилт 3. Ахмад настнуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, шинэ ур чадварт суралцуулж, амьдралын чанарыг дээшлүүлсэн байна.

|    |                                                                                                             |     |    |    |    |    |     |
|----|-------------------------------------------------------------------------------------------------------------|-----|----|----|----|----|-----|
| 1. | Ахмад настнууд ажлын байранд зуучлагдсан эсэх                                                               | Тоо | -  | 30 | 50 | 70 | 100 |
| 2. | Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан ахмад настны тоо                                                             | Тоо | 13 | 40 | 40 | 40 | 40  |
| 3. | Ахмад настнуудын үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа, сайн туршлагыг нутагшуулах чиглэлээр | Тоо | 1  | 2  | 4  | 4  | 4   |

|                                                                                                                                                                  |                                                                                                                  |     |   |      |      |      |      |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------|-----|---|------|------|------|------|
|                                                                                                                                                                  | зохион байгуулсан үйл ажиллагаа                                                                                  |     |   |      |      |      |      |
| Зорилт 4. Ахмад настны нийгмийн хамгааллыг сайжруулж, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр нөлөөллийн үйл ажиллагааг тогтмол зохион байгуулна. |                                                                                                                  |     |   |      |      |      |      |
| 1.                                                                                                                                                               | Ахмад настны нийгмийн хамгааллыг сайжруулах чиглэлээр зохион байгуулсан үйл ажиллагаа                            | Тоо | - | 2    | 4    | 4    | 4    |
| 2.                                                                                                                                                               | Ахмад настны нийгмийн хамгааллыг сайжруулах чиглэлээр зохион байгуулсан үйл ажиллагаанд хамрагдсан ахмад настууд | Тоо | - | 4500 | 4500 | 4500 | 4500 |